

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2021.07.02

Улиастай

"Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль, "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2018 оны А/520 дугаар захирамжаар батлагдсан "Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын дагуу аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагуудад иргэдээс мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар болон амаар, бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар хуваарийн дагуу иргэдтэй биечлэн уулзаж, өргөдөл, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч шийдвэрлэн хариуг өгч, бусад өдрүүдэд хэлтсийн дарга нар иргэдийг хүлээн авч уулзаж өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах 7046-1212 утсыг 24 цагаар ажиллуулж, ирүүлсэн санал, гомдлыг 7 хоногийн дотор шийдвэрлэн хариуг хүргүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

(Хүснэгт 1)

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	113	108	-	-	5	100.0
2	Нутгийн захиргааны байгууллага	3353	3013	38	54	248	98.3
II улирлын дүн		3466	3121	38	54	253	99.2

Аймаг, сумын Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт хандаж ирүүлсэн 3073 өргөдөл, 226 гомдол, 167 саналыг холбогдох хууль тогтоомж, эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэн, хариуг хүргүүлэн ажилласан байна.

Хуулийн хугацаанд нь 3121 өргөдлийг шийдвэрлэн хариу өгч, 38 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж, 54 өргөдөл хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 253 өргөдөл хугацаа болоогүй хүлээгдэж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт /хэлбэрээр/

(Хүснэгт 2)

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	ЗГИОНХ төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	113	86	-	-	10	17	-
2	Нутгийн захиргааны байгууллага	3353	2859	-	240	93	161	-
II улирлын дүн		3466	2945	-	240	103	178	-

Үүнээс Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвөөр дамжуулан 7 иргэн, аймгийн Засаг даргын иргэдээ сонсох 7046-1212 утсаар 17 иргэн хандаж, өргөдөл, санал, гомдлоо ирүүлээд байна.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга

(Хүснэгт 3)

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
1	Завхан аймаг	Нийт 2079 өргөдлөөс	1.Хүсэлт 3073 (88.6%)		
			2.Санал 167 (4.8%)		
			3.Гомдол 226 (6.5%)		
		Асуудлын нэр	Нийт тоо	Нийт хувь	
		Нийгмийн халамжтай холбоотой	852	24.7%	
		Ажил, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой	512	14.8%	
		Нийгмийн даатгалтай холбоотой	357	10.3%	
		Иргэний бүртгэлтэй холбоотой	322	9.2%	
		Газрын харилцаатай холбоотой	426	12.2%	
		Байгаль орчинтой холбоотой	166	4.8%	
		Ковид-19 холбоотой	235	6.8%	
		Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой	288	8.3%	
		Цалин тэтгэмжтэй холбоотой	38	1.1%	
Тусгай зөвшөөрөлтэй холбоотой	152	4.4%			
Бусад	118	3.4%			

	<p>1.Коронавируст халдварын цар тахалтай үед иргэдээс нийгмийн тусламж буюу түлээ, нүүрс, хоол, мөнгөн тусламж хүссэн өргөдөл ирүүлснийг аймаг, сумын Засаг даргын нөөц сангийн хүрээнд шийдвэрлэсэн.</p> <p>2.Согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, дахин сунгах хүсэлтийг үндэслэж аж ахуй нэгжүүдэд хяналт шалгалт явуулан, зөвшөөрлийг шаардлага хангасан хуулийн этгээдэд олгосон.</p> <p>3.Малчид нийгмийн даатгалд төлж, малчнаар тэтгэврийн насыг багасгасантай холбоотой тэтгэврээ тогтоолгох, нөхөн төлөлт хийлгэх хүсэлтийг ихээр гаргаж буйг шийдвэрлэсэн.</p>
--	---

Иргэдээ ирүүлсэн өргөдөл, саналаас шууд шийдвэрлэж, хүсэлтийг бүрэн барагдуулах боломжгүй өргөдлийг агуулгаар нь ангилж, дараах байдлаар гаргалаа.

(Хүснэгт 4)

№	Байгууллагын нэр	Шийдвэрлэхэд хүндрэлтэй өргөдлийн агуулга							
		Шүүхийн асуудал	Өндөр дүнтэй санхүүгийн тусламж	Орон сууцанд хамруулах	Гэр олгох	Зээлээс чөлөөлөх	Ажлын байраар хангах	Өндөр өртөгтэй эмчилгээний зардал	Бусад
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	1	1	2	1	-	5	1	-
2	Нутгийн захиргааны байгууллага	1	18	2	5	2	25	7	5
II улирлын дүн		2	19	4	6	2	30	8	5

Өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ тухай бүр асуудлыг судалж, шаардлагатай үед ажлын хэсгийг томилон дүгнэлт гаргасан. Мөн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР